

2009 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН БАЙДЛААРХ САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу Санхүүгийн мэдээллийн алба (СМА) банк болон банк бус санхүүгийн бусад байгууллагаас 20 сая төгрөг түүнээс дээш хэмжээний бэлэн мөнгөний гүйлгээний тайланг хүлээн авч мэдээллийн санд бүртгэдэг. Энэ үйл ажиллагааны хүрээнд 2009 оны эхнээс 2009 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар СМА нь нийт 15 банкнаас 127772 ширхэг бэлэн мөнгөний гүйлгээний тайланг хүлээн авсан. Ингэснээр тайланг албан ёсоор хүлээн авч эхэлсэн 2008 оны 2 дугаар сарын 4-ний өдрөөс 2009 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар СМА нь мэдээллийн сандаа 221978 ширхэг бэлэн мөнгөний гүйлгээний тайланг хүлээн авч бүртгээд байна.

Бэлэн мөнгөний гүйлгээний тайланг мэдээлэх явц жигд байна.

Сэжигтэй гүйлгээний тайлан

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.2 дахь заалтын дагуу мэдээлэх үүрэгтэй этгээд нь мөн мөнгө угаах эсхүл терроризмыг санхүүжүүлэх сэжигтэй гүйлгээний тухай тайланг бэлэн, бэлэн бус, мөнгөний дүн харгалзахгүйгээр СМА-д мэдээлж байх үүрэгтэй. Сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэх явц тун хангалтгүй байгаа бөгөөд 2009 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт зөвхөн 3 банкнаас 20 ширхэг сэжигтэй гүйлгээний тайланг СМА-д мэдээлсэн байна. Мөн түүнчлэн, бусад эх үүсвэрээс 4 ширхэг сэжигтэй гүйлгээний тайлан ирүүлсэн байна. Ингэснээр, СМА-ны мэдээллийн санд 2008 оны 2 дугаар сараас хойш ирүүлсэн нийт Сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо 36 ширхэг болж байгаа юм. Эдгээрийг мэдээллийн сандаа бүртгэж авахын зэрэгцээ бүгдэд нь дүн шинжилгээ хийсний үр дүнд 3 багц мэдээллийг шалгуулах, нэмэлт мэдээлэл авах зорилгоор холбогдох хуулийн байгууллагад шилжүүлээд байгаа бөгөөд бусад мэдээллийн талаар нэмэлт мэдээлэл цуглуулж байна.

СМА нь эдгээр тайланд дүн шинжилгээ хийх бололцоотой болж үндэслэл бүхий сэжигтэй гүйлгээ гэдгийг олж тогтоохын тул мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах, тэдгээрт дүн шинжилгээ хийх програм хангамж боловсруулах ажлуудыг Монголбанкны Мэдээллийн технологийн газартай хамтран хийж байна. Мөн түүнчлэн, шалгаж байгаа мэдээллийн тухай илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй болох, сэжиглэх үндэслэлийг улам баталгаажуулахтай холбогдуулж бусад төрийн байгууллагын мэдээллийн сангаас лавлагаа авдаг тогтолцоог бий болгохоор ажиллаж байна.

Хилээр тээвэрлэсэн бэлэн мөнгөний тайлан /декларацийн мэдээ/

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн дагуу иргэд байгууллагууд 5 сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют), түүнээс дээш бэлэн мөнгийг Монгол улсын хилээр тээвэрлэх тохиолдолд бэлэн мөнгөний деклараци бөглөж байх үүрэгтэй. Энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж Монголбанк, Гаалийн ерөнхий газрын 2008 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хамтарсан тушаалаар Гаалийн ерөнхий газар 2009 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн декларацийн мэдээг нэгтгэн Санхүүгийн мэдээллийн албанд сар бүр мэдээлдэг тогтолцоотой болсон. 2009 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар СМА нь нийт 4503 ширхэг декларацийн мэдээг Гаалийн ерөнхий газраас хүлээн авч бүртгээд байна.

Бусад байгууллагатай мэдээлэл солилцох үйл ажиллагаа

2009 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар СМА-нд төрийн байгууллагуудаас тодорхой хувь хүн, хуулийн этгээдтэй холбоотой мэдээлэл авах 6 хүсэлт ирүүлсэнд бүгдэд нь хариу өгсөн.

2009 оны 5 дугаар сарын 25-ны өдөр СМА нь олон улсын Санхүүгийн мэдээллийн албадын бүлэг болох Эгмонт бүлэгт элссэнээр Монголын СМА бусад 118 орны Санхүүгийн мэдээллийн албадтай шууд харилцаж мэдээлэл солилцох боломжоор хангагдсан. Үүний үр дүнд СМА нь 6 орны Санхүүгийн мэдээллийн албанд тодорхой дүн шинжилгээ болон бусад байгууллагаас ирүүлсэн лавлагааны хүрээнд тодорхой хувь хүн, хуулийн этгээдийн талаар мэдээлэл ирүүлэх хүсэлт явуулсан бөгөөд 3 орны СМА-наас хариу ирүүлсэн.

Мөн түүнчлэн, Эгмонтын гишүүн бус боловч манай СМА-тай мэдээлэл солилцох хоёр талын Санамж бичиг зурсан гадаадын нэг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл авах хүсэлт явуулсан бөгөөд лавлагааны хариуг богино хугацааны дотор хүлээн авсан. СМА нь одоогийн байдлаар 4 орны СМА-тай Санамж бичгийн хүрээнд хамтран ажиллаж байна.

Хяналт шалгалт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 17.2 дахь заалтын дагуу СМА мэдээлэх үүрэгтэй этгээдийн хуулийг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах үүрэгтэй. Үүнтэй холбогдуулж Монголбанкнаас банкуудад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой хяналт шалгалт хийх тухай тусгайлсан журмыг 2009 оны 3 дугаар сарын 16-ны өдөр баталж гаргасан бөгөөд түүнээс хойш СМА нь Монголбанкны Хяналт шалгалтын газартай хамтран банкуудад газар дээрх шалгалт хийдэг болсон. 2009 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар СМА болон ХШГ нь нийт 11 банкинд газар дээрх хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд нийт 2 банкинд байцаагчийн акт 11 хугацаат үүрэг даалгавар өгөн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА